



Ажил олгогчийн эрх, үүрэг



МОНГОЛ
УЛСЫН
ХАМГАА
ГАХ
ДИР
СҮРГЭЛ

БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН
НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ГАЗАР

АЖИЛ ОЛГОГЧ, ДААТГУУЛАГЧИЙН ЭРХ,
ҮҮРГИЙГ ТОДОРХОЙ БОЛГОСОН

АЖИЛ ОЛГОГЧИЙН ЭРХ:

шимтгэлийн хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэх

илүү төлсөн нийгмийн даатгалын шимтгэлийг буцаан
авах, шилжүүлэн тооцуулах

нийгмийн даатгалын асуудлаар лавлагаа тодорхойлолт,
мэдээлэл, зөвлөгөө авах болон сургалтад хамрагдах

эрх бүхий байгууллагын шалгалтын дүн, акттай
танилцах, тайлбар авах, өгөх

хууль зөрчсөн үйл ажиллагаа, шийдвэрийн талаарх
гомдол гаргах

хууль тогтоомжид заасан бусад эрх

АЖИЛ ОЛГОГЧИЙН ҮҮРЭГ:

ажилтантай хөдөлмөрийн гэрээ болон бусад гэрээ байгуулсан
өдрөөс эхлэн түүнийг нийгмийн даатгалд даатгуулах

орон тоо болон цалин хөлсний бүрэлдэхүүнийг үнэн зөв
тодорхойлж, нийгмийн даатгалын шимтгэлийг сар бүр төлөх

нийгмийн даатгалын шимтгэл төлөлттэй холбоотой баримт
бичгийг тухай бүр нийгмийн даатгалын байгууллага,
даатгуулагчид өгөх

эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас тогтоосон акт, албан
шаардлага, мэдэгдэл зэргийг хугацаанд нь биелүүлэх

ажил олгогчийн буруугаас даатгуулагчид учирсан хохирлыг
бүрэн хариуцаж төлөх

ажилтныг нийгмийн даатгалын хууль тогтоомж, нийгмийн
даатгалын шимтгэл төлөлтийн мэдээллээр хангах